

2024 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2024 оны 06 дугаар сарын 12-ны “Лхагва” гарагт багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, ТЗУХ-ийн мэргэжилтэн (ЕРП Б.Одбаяр)-д файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Нийслэлийн хэмжээнд орон сууцны талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахаар бэлтгэж байгаа тул дүүргээс холбогдох саналыг боловсруулж хүргүүлэх.	ЗДО Б.Болормаа ЗДТГ, ААНБ
2	Инженерийн хангамжийн байгууллагуудад ямар мэргэжлийн, ямар туршлагатай, хэдэн инженер хэрэгцээтэй байгаа талаар тоон мэдээллийг нэгтгэж танилцуулах, холбогдох байгууллагад хүргүүлэх.	ТХҮХ, Инженер хангамжийн байгууллагууд
3	Хог, хаягдлыг цагийн хуваарийн дагуу ачиж, тээвэрлэх зохицуулалтыг жигдрүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих.	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
4	Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй барилгын хог хаясан болон бусад хог хаягдал үүсдэг байршлуудад хяналтын камер суурилуулах ажлыг зохион байгуулах.	Цагдаагийн хэлтэс, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
5	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд зөвшөөрөлгүй гар дээрх худалдаа, үйлчилгээ эрхэлж буй иргэдийн үйл ажиллагааг цэгцлэх ажлыг зохион байгуулах.	ТХҮХ, Цагдаагийн хэлтэс
6	Дүүргийн хэмжээнд гэрэлтүүлгийн асалтад хяналт тавьж, асалт хангалтгүй байгаа гэрэлтүүлгийг засаж, асалтыг 100 хувьд хүргэх.	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
7	Нийслэлийн төсвийн орлого бүрдүүлэх ажлыг эрчимжүүлж, орлого бүрдүүлэхэд зохион байгуулалтын арга хэмжээ авч, жигд ханган нийлүүлэх.	СТСХ, Татварын хэлтэс
8	Баянзүрх дүүргийн 27 дугаар хорооны нутаг дэвсгэрт үерт өртсөн айл өрхүүдийн газрыг чөлөөлж, орон сууц олгож, үерээс урьдчилан сэргийлэх хүрээнд үерийн бүсэд байгаа айл, өрхүүдийг БНД, БХД, НД болон СХД-ийн Өлзийт хороололд газар олгох ажлуудыг зохион байгуулах тул холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	ЗДО Б.Болормаа, ГЗБА
9	Зам тээврийн зөрчил гаргаж байгаа тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааг зохицуулах хүрээнд нийслэлийн Цагдаагийн Удирдах газраас торгуулийн хувь хэмжээг арав дахин нэмэгдүүлэх саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэхтэй холбогдуулан дүүргээс санал боловсруулж хүргүүлэх.	Цагдаагийн хэлтэс
10	Дүүргийн хэмжээнд инженерийн шугам сүлжээний засвар шинэчлэлийн ажлыг замын хөдөлгөөнд саад учруулахгүйгээр зохион байгуулж, гүйцэтгэл, чанар, стандартад хяналт тавьж ажиллах.	ТХҮХ, Соёлын ордон, ЦХ-ийн ЗЦХ
11	Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд ААНБ-уудаас санал авч, төлөвлөгөө гаргах.	ТХҮХ, Хороод, ААНБ-ууд
12	Дүүргийн Засаг даргын орлогч нар өөрсдийн нутаг дэвсгэрээр явж эвдэрч гэмтсэн явган зам, талбайг засаж	ЗДО Б.Болормаа

	сайжруулах ажлыг зохион байгуулах.	
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
13	2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэх УИХ-ын сонгуулийн сурталчилгаа эхэлж, нэгдсэн самбар байршуулахтай холбогдуулан гэрэлтүүлгийн асалтыг шөнийн цагаар асаах, холбогдох ААНБ-ууд камер нэмж байрлуулах шаардлагатай тул ажлын уялдаагаа сайжруулан ажиллах.	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
14	2023-2024 оны хичээлийн жилийн ЕБС, СӨББ-уудын төгсөлтийн арга хэмжээтэй холбогдуулан эрсдэл, зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, анхаарч ажиллах.	Боловсролын хэлтэс
15	Мод бут, сөөгийг хэлбэржүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах.	Нийт байгууллагууд
16	Хөрөнгө оруулалтын ажлуудын явцыг эрчимжүүлэн, хяналтаа сайжруулах.	ТХҮХ, Ажлын хэсэг
17	Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажлыг хангах хүрээнд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан Ажлын хэсэг ажлын уялдаагаа сайжруулан бэлтгэлийг хангах.	Ажлын хэсэг
18	ААНБ-ууд ойр орчмын талбайдаа мод, бут, цэцэг тарих ажлуудыг яаралтай зохион байгуулж, арчилгаа хамгаалалтад анхаарах.	Нийт байгууллагууд
19	Нийслэлд төсвийн тодотгол хийгдэхтэй холбогдуулан уялдаа холбоотой байж шаардлагатай төсвийг шийдвэрлүүлэхэд анхаарах.	СТСХ
20	Фокус бүлгийн уулзалтын хүрээнд байгуулагдсан гэрээний хэрэгжилтийг нэгтгэн танилцуулах, ажлуудаа эрчимжүүлэх.	ЗДТГ, ААНБ-ууд
21	“Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-ын хашааны зүүн талыг засаж янзлах.	Багахангай тохижилт ОНӨААТҮГ

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР